



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/184

Ховд

Захирамж хэрэгжих хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт Covid-19-ийн тохиолдол батлагдсантай холбогдуулан Аймгийн төв, сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бар, ресторан, караоке, зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагааг түр хязгаарлах тухай аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/180 дугаартай захирамжийн хэрэгжих хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 23.00 цагаас 04 дүгээр сарын 12-ны өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ